

ИЛ БОЛСОН

МАШ НУУЦ

БАТЛАВ.
“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Н.УДААНЖАРГАЛ

БАТЛАВ.
“ГЕО ИНЖЕНЕРИНГ ГРУПП”
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Д.БАЯРСАЙХАН

ХУДАГ ӨРӨМДӨХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2022 оны 08 сарын
08-ны өдөр

№ *ТТЗ-ММ21/05*

Улаанбаатар
хот

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

Монгол улсын иргэний хуулийн 343-358 зүйлүүдийг тус тус үндэслэн нэг талаас “Тавантолгой төмөр зам” ХХК /цаашид “Захиалагч” гэх/, түүнийг төлөөлж Төсөл хөгжлийн газрын дарга Э.Эрдэнэбат, нөгөө талаас “Геоинженеринг групп” ХХК /цаашид “Гүйцэтгэгч” гэх/, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Д.Баярсайхан нар дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Гэрээний зорилго нь Захиалагчийн хэрэгжүүлэх Богдхан төмөр замын төсөл /цаашид “Төсөл” гэх/-ийн ус хангамжийн худгийг чанарын өндөр түвшинд гүйцэтгэхтэй холбоотой эрх үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлж, хамтын ажиллагаа, харилцан ойлголцлыг зохицуулахад оршино.
- 1.2. Гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох ба гэрээгээр хүлээсэн үүрэг биелэгдсэнээр дуусгавар болно.
- 1.3. Гэрээний хавсралт:
 - Гэрээний хавсралт №1 Ажлын даалгавар

ХОЁР.ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1. Гүйцэтгэгч нь Гэрээний хавсралт №1-т заасан ажлын даалгаварын дагуу холбогдох стандартад нийцсэн судалгааны төвийг бүрэн хүлээлгэн өгөх үүрэгтэй.
- 2.2. Гүйцэтгэгч нь Төслийг хэрэгжүүлэх явцад нарийн төвөгшилтэй болон, технологийн шийдэл бүхий төнөг төхөөрөмж захиалах явцад Захиалагчаас чиглэл авах үүрэгтэй.
- 2.3. Гүйцэтгэгч нь шаардлагатай тохиолдолд захиалагчаас мэргэжлийн тусламж зөвлөгөө авах эрхтэй.

- 2.4. Гүйцэтгэгч нь өрөмдлөгийн ажлыг Захиалагчийн батлагдсан ажлын даалгаварын дагуу чанартай, стандартын дагуу Захиалагчийн тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэнэ.
- 2.5. Гүйцэтгэгч нь Захиалагчийн захиалгын дагуу нэмэлт худгийг гэрээнд заагдсан нэгж худгийн үнээр ажлыг гүйцэтгэнэ.
- 2.6. Гүйцэтгэгч нь өрөмдлөгийн үеийн болон худаг бүрэн ашиглалтанд оруулах хүртлэх бүх бараа материалыг бүрэн хариуцна.
- 2.7. Гүйцэтгэгчийн өрөндсөн цооног Захиалагчийн ажлын даалгаварт заасан ундрагад хүрэхгүй тохиолдолд тухайн зардлыг Гүйцэтгэгч хариуцна.
- 2.8. Худгийн баталгаат хугацаа нь Захиалагч худгийн паспорт хүлээн авсан өдрөөс эхлэн 6 сар байна. Баталгаат хугацааны засварт захиалагчийн буруутай үйл ажиллагаанаас үүссэн эвдрэл хамаарахгүй.
- 2.9. Насос болон дагалдах эд ангийн баталгаад хугацаа Захиалагч худгийн паспорт хүлээн авсан өдрөөс эхлэн 6 сар байна. Баталгаат хугацааны засварт захиалагчийн буруутай үйл ажиллагаанаас үүссэн эвдрэл хамаарахгүй.
- 2.10. Гүйцэтгэгч нь Захиалагчид урьдчилан мэдэгдэлгүйгээр нэмэлт өрөмдлөг хийсэн тохиолдолд зардлыг Гүйцэтгэгч хариуцна.

ГУРАВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1. Захиалагч нь гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг шаардах, гүйцэтгэгч талаас тайланг хугацаанд нь авах эрхтэй.
- 3.2. Захиалагч нь баталгаат хугацаанд гүний худгийн засвар үйлчилгээ хийлгэхээр болсон тохиолдолд гүйцэтгэгчтэй холбогдож, хамтран ажиллана.
- 3.3. Захиалагч нь Ажлын даалгаварын дагуу Гүйцэтгэгчид заавар, зөвлөмж хүргүүлэх болон өрөмдөлгийн явцад хяналт тавих эрхтэй.
- 3.4. Захиалагч нь хэрэгцээ шаардлагын дагуу нэмэлт худгийг Гүйцэтгэгчид хүсэлт гаргасны үндсэн дээр нэмэлтээр худгийн ажлыг хийлгэх эрхтэй.
- 3.5. Захиалагч нь Ажлын даалгаварын дагуу хийгдсэн бүрэн ажиллагаатай худгийн төлбөрийг төлөх үүрэгтэй.

ДӨРӨВ. ТӨЛБӨР ТООЦОО

- 4.1 Энэхүү гэрээний дагуу Захиалагч нь Гүйцэтгэгч талд гэрээний төлбөр бүрэн тоноглол бүхий хэвийн ажиллагаатай нэг худгийн төлбөр болох 143,750,000.00 /Нэг зуун дөчин гурван сая долоон зуун тавин мянган/ төгрөгийг Голомт банк дахь 1410001211 тоот дансанд гэрээний 4.2-т заасны дагуу шилжүүлнэ.

- 4.2 Гэрээ байгуулагдаж баталгаажуулан, ажил эхэлснийг батлаж фото зураг, дүрс бичлэг болон захиалагчийн хяналтын ажилтнуудын акт зэргийг ирүүлсэн өдрөөс хойш ажлын хуанлин 10 /арав/ хоногт багтаан гэрээний 4.1-т заасан төлбөрийг шилжүүлнэ.
- 4.3 Захиалагчийн хүсэлтийн дагуу нэмэлт худаг гаргасан тохиолдолд нэмэлт худгийн үнэ гэрээний 4.1-т заасан нэгж худгийн үнээр тооцогдоно.
- 4.4 Энэхүү гэрээ нь 2022 оны 8 дугаар сарын 10-ны өдрөөс 2022 оны 9 дүгээр сарын сарын 25 -ны өдрийг хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр байна.

ТАВ. БУСАД ЗҮЙЛ

- 5.1. Энэхүү гэрээнд тусгагдаагүй аливаа асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.
- 5.2. Энэхүү гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахтай холбогдсон асуудлыг талууд харилцан тохиролцож, бичгээр гэрээ байгуулж шийдвэрлэх ба энэ нь талуудын гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажсанаар хүчин төгөлдөрт тооцогдоно.
- 5.3. Энэхүү гэрээ адил хүчинтэй 3 (гурван) хувь үйлдэгдэж, талууд тус бүр нэг, нэг хувийг хадгална.
- 5.4. Энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой талуудын хооронд маргаан гарвал талууд үл маргах журмаар асуудлыг шийдвэрлэхийг эрмэлзэх ба харилцан тохиролцоонд хүрээгүй тохиолдолд маргааныг Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Захиалагчийг төлөөлж:
“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн
Төсөл хөгжлийн газрын дарга

Б.Эрдэнэбат

Гүйцэтгэгчийг төлөөлж:
“Гео инженеринг групп” ХХК-ийн
Үйл ажиллагаа хариуцсан менежер

Б.Байгалмаа

“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛН УДААНЖАРГАЛ

БОГДХАН ТӨМӨР ЗАМ ТӨСЛИЙН УС ХАНГАМЖИЙН АЖЛЫН ДААЛГАВАР

Нэг: Ажлын зорилго

Төв аймгийн Аргалант, Алтанбулаг, Баян, Сэргэлэн сумд, Улаанбаатар хотын Сонгино хайрхан дүүргийн 21, 32 дугаар хороод, Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны нутагт баригдах Богдхан төмөр зам төслийн бүтээн байгуулалтын 2022 оны эхлэлийн үе (37.5 км урт далан, 2 зөрлөг, 5 гүүр, 47 хоолой барих)-д шаардагдах 2441.5 м³/хоног буюу 28.3 л/сек усны эх үүсвэр илрүүлж, гидрогеологийн судалгаа, өрөмдлөгийн ажлуудыг гүйцэтгэх, тоног төхөөрөмжийн ханган нийлүүлэлт хийх (тоолуур, худгийн насос, ус нөөцлөх сав 60 тн ба 10 тн), батлагдсан зургийн дагуу худгийн байшин барилга угсралтын ажил, ашиглалт үйлчилгээ гэсэн үндсэн 5 чиглэлийн ажлыг гүйцэтгэн түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр гүйцэтгэхэд энэхүү ажлын зорилго оршино.

Хоёр: Гүйцэтгэх ажлын хүрээ

- Талбайн геофизикийн судалгаа явуулах талбайг сонгох;
- Талбайн геофизикийн судалгааны ажлын хэмжээг тодорхойлох, үр дүнг хянах, өрөмдлөг явуулах цэгийг сонгох;
- Сав газрын захиргаанас ашиглалтын цооног өрөмдөх зөвшөөрөл авах баримт бичгийг боловсруулах, зөвшөөрөл авах;
- Өрөмдлөгийн ажлын явцад байнгын хяналт тавих, гидрогеологийн мэдээлэл цуглуулах, цооног тоноглох захиалгыг бэлтгэх;
- Цооногийг худгийн гормид шилжүүлэх, паспортуудыг холбогдох газраас авах, захиалагчид өгөх;
- Худагт тоолуур, ус нөөцлөх сав суурилуулах, хамаарах сум дүүргийн МХБ –аар баталгаажуулах;
- Ус түгээлтийг хийх;
- Тоног төөрөмжүүдийг нийлүүлж, засвар үйлчилгээг хийх;

2.1 Өрөмдлөг ба тоноглолт

Өрөмдлөгийн ажлаар ашиглалтын 6 цооног өрөмдөх бөгөөд цооногуудын дундаж гүн 40-100 тууш метр. Ашиглалтын цооногийн өрөмдлөгийн диаметр 250мм, тоноглолтын диаметр 158 мм-ийн төмөр шүүр яндан. Цооногийн өрөмдлөгийн эцсийн гүн талбайн гидрогеологчийн дүгнэлтээр шийдвэрлэгднэ.

Цооногт 158мм шүүр яндан суулгах бөгөөд шүүрийн арын орон зайгаар 3-6мм-ийн ширхэглэгдсэн, мөлгөр хайргаар хайрган шүүр хийж, түүний дээр шавран болон цементэн тампонаж хийнэ. Цооногуудын цэвэрлэгээний үед ундаргын хэмжилтийг хийх.

2.2 Цооногийн цэвэрлэгээ

Өрөмдөгдөж тоноглогдсон бүх цооногуудыг эрлифтийн аргаар цэвэрлэх бөгөөд цэвэрлэгээний явцад ундаргын хэмжилтийг гүйцэтгэх ба түвшин бууралтыг хэмжих.

2.3 Ус давхаргын шавхалт-туршилт

Цооногийг цэвэрлэгээ дууссаны дараа уст давхаргын нарийвчилсан мэдээллийг авах, гидрогеологийн тооцооны параметруудийг тогтоох зорилгоор шавхалт-туршилтын ажлыг гүйцэтгэнэ. Уст давхаргын туршилтаар дараах туршилтуудыг гүйцэтгэх. Үүнд:

Тохируулах шавхалт

1-р бууралтын шавхалт – 24 цаг

Түвшний сэргэлтийн хэмжилт

2-р бууралтын шавхалт – 48 цаг

Түвшний сэргэлтийн хэмжилт

Тохируулах шавхалтаар шавхалтын багаж төхөөрөмжийн бүрэн бүтэн ажиллагааг шалгах, мөн тогтмол ундаргатай шавхалтыг явуулах оновчтой ундаргыг тогтоох.

1-р түвшин бууралтыг тогтоох зорилгоор шавхалтын ажлыг 24 цаг үргэлжлэн хийгдэх бөгөөд түвшний сэргэлтийн мөн хэмжинэ.

Усны түвшин сэргэсэн үед 2-р түвшин бууралтын шавхалтыг 48 цагийн үргэлжлэлтэй гүйцэтгэж, сэргэлтийн туршилтийг усны түвшний 95% хүртэл хэмжих.

Бүх туршилтын явцад түвшин бууралт болон сэргэлтийн хэмжилтийг даралтын автомат багажаар 30 секунд тутамд хэмжинэ. Мөн цахилгаан түвшин хэмжигчээр усны тогтсон түвшинг хэмжинэ.

2.4 Топогеодезийн холболт

Цооногуудын байршлыг гар GPS багажаар хэмжиж тодорхойлох.

2.5 Гидрогеологийн хээрийн ажил

Талбайд нэг гидрогеологич ажиллуулах бөгөөд өрөмдлөгийн үед гидрогеологийн мэдээлэл цуглуулах, уст давхаргын туршилтад зааварчилгаа өгөх, хэмжилтийг гүйцэтгэж дараах үйл ажиллагааг хариуцна. Үүнд:

- Цооногийн тоноглолтонд шаардлагатай материалуудыг бүртгэх, тоолох
- Өрөмдлөгийн машиныг тогтоогдсон цэг дээр гар GPS-ээр байршуулах
- Өрөмдлөгийн ажлын үйл явцаг бүртгэх
- Литологийн бичиглэл хийх
- Өрөмдлөгийн гүнийг хэмжиж, баталгаажуулах
- Цооногийн тоноглолт болон цэвэрлэгээний үед зааварчилгаа өгөх, гүйцэтгэлийг хянах
- Шавхалтын ажлыг иж бүрнээр удирдан зохион байгуулах
- Шавхалтын ажилд хэрэглэгдэх автомат багажуудыг тохируулах, ажилд бэлтгэх

2.6 Талбайн геофизик

“Богдхан төмөр зам” төслийн ус хангамжид зориулсан цооногийн байршил болон өрөмдөх гүнийг нарийвчлан тогтоох, газрын доорх ус агуулагч ан цав, хагарлыг тогтоох талбайн геофизикийн хайгуулыг сонгосон талбайд ВЭЗ болон РАП-ын аргуудар хэмжилт хийх шаардлагатай. Геофизикийн хайгуулаар 40-100 м-ийн гүний мэдээллийг гарган авч цооногийн байршил тогтоож тайлан гаргаж захиалгачид хүргүүлэх.

Гурав: Өрөмдлөгийн ажил гүйцэтгэх зөвшөөрөл

Өрөмдлөгтэй холбоотой төрийн захиргааны байгууллагаас авах зөвшөөрлийг захиалагч тал хариуцах бөгөөд үүнд гүйцэтгэгч дэмжлэг үзүүлнэ. Өрөмдсөн цооногуудыг худгийн горимд шилжүүлж, паспортын бичилтыг хийж, захиалагчийн нэр дээр бүртгүүлэх ажлыг гүйцэтгэгч хариуцана.

Дөрөв: Талбайн зохион байгуулалт болон нөхөн сэргээлт

Өрөмдлөгийн ажил явагдах талбайг тусгай гэрэл ойгчтой туузаар тусгаарлаж, хувийн хөдөлмөр хамгааллын хэрэгсэлээ бүрэн өмсөхийг анхааруулсан зурагт зааварчилгаа байршуулах хэрэгтэй. Мөн шаардлагагүй тохиолдолд өрөмдлөгийн талбайд хүн нэвтрүүлэхгүй байх.

Өрөмдлөг болон цооногийн тоноглолт дуусч цооног гүйцэт цэвэрлэгдсэний дараа өрөмдлөгийн талбайг цэвэрлэх, гадаргууг тэгшлэх мөн цооногийн эргэн

ИЛ БОЛСОН

МАШ НУУЦ

тойрон 200 м радиусыг орчны бохирдолгүй байлгах үүрэгтэй. Хөрсөнд шатах, тослох материал асгахгүй байх, аюулгүй ажиллагаах хангаж ажиллах.

Ашиглалт дууссан худгуудыг цооногийн горимд шилжүүлэх, битүүмжлэн захиалагч талд хүлээлгэн өгөх үүрэгтэй.

---ooOoo---